



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/99

Өвт

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн хуучин хогийн цэг орчмын цэвэрлэгээ, хог зайлуулалтыг хийх, хогийн цэгийг ландфилын аргаар дарж, булшлах, хогийн цэг шинээр байгуулах ажлуудын гүйцэтгэлийг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Бат-Эрдэнэ-Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд: С.Төмөр-3 дугаар багийн Засаг дарга

Л.Балжинням-5 дугаар багийн Засаг дарга

Б.Янжиндулам-Байгаль орчны хяналтын улсын байцаагч

П.Жамбалдагва-Иргэний төлөөлөл

2. Захиалагчийн техникийн тодорхойлолтод заасны дагуу хүлээн авч, акт үйлдэн ажлын гүйцэтгэл, үр дүнг ажлын хэсэг (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

М.ЖАМЪЯНШАРАВ

